

3.1. “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх зорилтын хүрээнд:

3.1.1. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацааг сунгах, нөхөн олгох талаар санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан бүрдүүлж хөтлөх, баяжуулах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах үйл ажиллагааг эрх шилжүүлсний үндсэн дээр хэрэгжүүлэх.

2022.09.16-ний өдрийн байдлаар гэрчилгээжүүлэлттэй холбоотой 339 хүсэлт ирсэн бөгөөд ажлын хэсгийн 16 удаагийн хурлаар 247 хуулийн этгээдийн хүсэлтийг хэлэлцэж 87 хуулийн этгээдэд 828 гэрчилгээ шинээр олгож, 114 хуулийн этгээдийн 176 гэрчилгээний хугацааг сунгаж, 5 хуулийн этгээдэд 6 гэрчилгээний мэдээлэлд өөрчлөлт оруулах асуудлыг ЗТХСайдын 2022 оны А/02, А/12, А/13, А/22, А/51, А/52, А/70, А/71, А/82, А/84, А/85, А/91, А/92, А/109, А/110, А/111, А/141, А/142, А/143, А/144, А/145, А/177, А/178, А/204, А/205, А/206, А/217, А/218, А/221, А/235, А/241, А/242 дугаар тушаалаар шийдвэрлүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан А/02, А/12, А/13, А/22, А/51, А/52, А/70, А/71, А/82, А/84, А/85, А/91, А/92, А/109, А/110, А/111, А/141, А/142, А/143, А/144, А/145, А/177, А/178, А/204, А/205, А/206, А/217, А/218, А/221, А/235, А/241, А/242 тушаалыг тус тус үндэслэн 206 иргэн, хуулийн этгээдийн 1010 ширхэг гэрчилгээг хэвлэж, Төвийн захирлын тамга, гарын үсгээр баталгаажуулан иргэн, хуулийн этгээдэд олгосон. Ажлын хэсгээс дэмжин ЗТХЯ-нд уламжлан шийдвэрлэгдэх шатанд 11 хүсэлт 16 гэрчилгээ байна. Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж журмын шаардлага хангахгүй шалтгаанаар 41 хүсэлтийг албан бичгийн хамт буцаасан бол баримт бичгийн бүрдэл дутуу шалтгаанаар 92 хүсэлтийг буцаасан. Ажлын хэсгийн хурлаар орохоор хүлээгдэж буй 5 хүсэлт байна. Тус арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшин буюу төлөвлөсөн үр дүнд хүрсэн гэж үзэж байна.

Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг тухай бүр бүрдүүлж хөтлөн, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.8-д заасны дагуу гэрчилгээ олгосон хуулийн этгээдүүдийн мэдээллийг ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т 2022 оны 8 дугаар сарын 31-ны өдөр тайлагнасан.

1.4.Удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргах, хяналт, шалгалт хийх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх зэрэг ажилд оролцохын өмнө тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж байх; байнгын

Гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсэг 2022 оны 09 дүгээр сарын 16-ны байдлаар ажлын хэсгийн 16 удаагийн хурал хуралдаж хүсэлт ирүүлсэн нийт 222 иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг ажлын хэсгийн гишүүд хуралд оролцохын өмнө тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг бөглөн гарын үсгээр баталгаажуулан ажлын хэсгийн нарийн бичигт цахимаар хүлээлгэн өгч, ажлын хэсгийн нарийн бичиг нэгтгэн PDF хэлбэрээр Төвийн нягтлан бодогчид хүлээлгэн өгч ажиллаж байна.